

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 1 удаа хуралдаж 10 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

“Шийдэл” үндэсний бодлогын хэлэлцүүлэг 21 аймаг 9 дүүргийн хэмжээнд зохион байгуулагдаж, уг арга хэмжээнд аймгийн хэмжээнд хүүхдийн хүчирхийллийг бууруулах, таслан зогсооход тулгарч буй бэрхшээл, боломжуудын талаарх нөхцөл байдлыг хэлэлцэж, цаашдын хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцож, зөвлөмж боловсруулан, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч, холбогдох төрийн өндөр албан тушаалтнууд болон Улаанбаатар хот дахь аймгийн нутгийн зөвлөлийн гишүүдтэй аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нар Улаанбаатар хотноо 2021 оны 09 дүгээр сарын 11,12-ны өдрүүдэд уулзалт зохион байгууллаа. Энэ үеэр “Алтайн брэнд” бүтээгдэхүүнийг сурталчилах, борлуулалтыг нэмэгдүүлж, зах зээлийг тэлэх зорилгоор Алтай нутгийн бүтээгдэхүүнээр хүндэтгэл үзүүлж, аймаг, орон нутгаа сурталчиллаа. Удирдлагын академийн эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 2, ахлах түшмэлийн багц сургалтад 2, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 8, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 9 албан хаагчийг тус тус хамруулахаар судалгааг хүргүүллээ.

Төрийн албаны ерөнхий шалгалтын бүртгэлийг 2021.09.22-2021.10.22-ны өдрүүдэд [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn) цахим хаягаар бүртгэж байна.

Төрийн албаны шинэтгэл, төрийн албаны тусгай шалгалтын программын нэвтрүүлэлт, анхаарах асуудлаар Төрийн албаны салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдтэй цахим уулзалт зохион байгууллаа. Мөн 4 удаагийн сургалтыг зохион , төрийн байгууллагуудын 200 гаруй төрийн албан хаагч хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол-Оросын парламентын бүлгийн дэд дарга Б.Энх-Амгалангийн санаачилгаар Монгол Улс, ОХУ хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жил, Найрамдлын 61 дэх өдрийг угтан “Баруун бүсийн орос хэлний мэдлэг чадварыг сорих, багш нарын туршлага солилцох” арга хэмжээ, орос дуу, уран уншлагын тэмцээн, уран зургийн үзэсгэлэнг Алтай хотод 9 дүгээр сарын 26-ны өдрөөс 28-ны өдрүүдэд тус аймагт амжилттай зохион байгууллаа. Орос хэлний мэдлэг сорих уралдаанд баруун таван аймгийн ЕБС-ийн 25 сурагч, орос хэлний 15 багш оролцсон бөгөөд ОХУ-д тэтгэлгээр суралцах сурагчдыг математик болон байгалийн ухааны хичээлүүдээр мөн шалгалт авч, 6 сурагчийг шалгарууллаа. Мөн 5 багшийг шилдгээр шалгаруулж, мэргэжил дээшлүүлэх курст суралцах эрхийн бичгээр шагналаа.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр БШУЯ болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамтай хамтран хэрэгжүүлж буй Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн хүрээнд Насан туршийн боловсролын төвд ажил мэргэжлийн чиг

баримжаа олгох мэдээллийн танхим байгуулагдаж, 9 дүгээр сарын 24-ний өдөр нээлтээ хийлээ.

Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газар, Мэдээллийн технологийн үндэсний парк хамтран “Мэдээллийн технологийн хүний нөөцийн ур чадварыг нэмэгдүүлэх”, Мэдээллийн технологийн инженерийн шалгалтын мэдээлэл өгөх семинарыг 09 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулж, 150 албан хаагч оролцон мэдлэг чадвараа дээшлүүллээ.

**Гамшгаас хамгаалах чиглэлээр:** Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд аймгийн Онцгой комиссын бүрэлдэхүүн 09 дүгээр сард 5 удаа хуралдуулж, үндсэн 11, нэмэлтээр 4 нийт 16 асуудал хэлэлцэж, 23 төрлийн шийдвэр, 1 удаагийн албан даалгавар гарган, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Аймгийн албаны бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, тэмцэх арга хэмжээ, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажилд зориулж аймгийн Гамшгийн сангаас Есөнбулаг сум дахь Эрэн хайх, аврах салбар байрлах Онцгой байдлын хуучин барилгын засварын ажилд шаардагдах 19.7 сая төгрөг, Цогт сум дахь Эрэн хайх, аврах бүлэг байрлах Эрүүл мэндийн төвийн хуучин барилгын засварын ажилд шаардагдах 19.9 сая төгрөг, Есөнбулаг сумын Наран багийн Дөтийн давааны зам засварын ажлыг гүйцэтгэхэд 6.0 сая төгрөг, халаалт дулааны зардалд 12.5 сая төгрөгийг тус тус шийдвэрлэн, бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллалаа.

Аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагуудаас гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн үүссэн нөхцөл байдалтай холбогдуулж 1 удаа хуралдаж, 5 асуудлыг хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гарган, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсэн хугацааг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 06:00 цагаас 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэл сунгаж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг 258 объектод 26 үзүүлэлтээр шалгалт хийж, 167 зөрчил илрүүлж, 86 зөрчлийг арилгууллаа.

Гал түймрийн улмаас иргэдэд 52.0 сая төгрөгийн хохирол учирч, 76.0 төгрөгийн өмч хөрөнгийг гал түймрийн аюулаас авран хамгаалсан.

**Өргөдөл гомдлын шийдвэрлэлт:** Тайлант хугацаанд аймгийн 16 өргөдөл бичгээр ирснээс 2 өргөдлийг шийдвэрлэж, 14 өргөдөл хяналтын шатандаа, хугацаандаа судлагдаж байна. Хугацаа хэтэрсэн өргөдөл гомдол байхгүй. Шийдвэрлэлт 12,5% байна.

“Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111” дугаарын утсанд 09 сарын байдлаар нийт 63 дуудлага хүлээн авснаас, хувийн мэдээллээ бүрэн өгсөн 46 гомдол, санал, хүсэлтийг E-office программд бүртгэн, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллалаа. Шийдвэрлэж хариу өгсөн 28,

хугацаандаа судлагдаж байгаа 18, хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй байна. Шийдвэрлэлт 58.7% байна.

**Цахим үйлчилгээний талаар:** E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн цахим операторын системээр нийт 54 нэр төрлийн лавлагаа, мэдээллийг иргэдэд нэг шатлалаар олгож байна.

Улсын бүртгэлийн цахим үйлчилгээний системээс гарах лавлагаа тодорхойлолтуудыг үнэ төлбөргүй олгохоор шийдвэрлэсний дагуу 07 сарын 01-ний өдрөөс төрийн мэдээлэл солилцооны “Хур” системээс гарч байгаа Улсын бүртгэлийн Ерөнхий газрын лавлагаа мэдээллүүдийг оператороор болон E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн портал сайтаар үнэ төлбөргүй олгож байна.

Тайлант хугацаанд операторын системээр иргэдэд олгох боломжтой 54 төрлийн төрийн цахим мэдээллийн үйлчилгээг 10 иргэнд төлбөртэй, 30 иргэнд төлбөргүй гаргаж үйлчиллээ. Нийт [WWW.OPERATOR.E-MONGOLIA.MN](http://WWW.OPERATOR.E-MONGOLIA.MN) цахим мэдээллийн системээр үзүүлсэн лавлагаа, тодорхойлолтын үйлчилгээний хураамж болох 8000 төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлээ.

Төрийн цахим үйлчилгээний E-mongolia сайтыг иргэдэд танилцуулах, шаардлагатай лавлагаа тодорхойлолтуудыг нэг шатлалаар богино хугацаанд авах, цахим порталын хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс үйлчилгээний нэгдсэн төвөөс иргэдэд мэдээ мэдээлэл, заавар зөвлөмжийг байнга өгч ажиллалаа. Иргэдийн хүсэлтээр хувийн мэдээллээр нь бүртгэл үүсгэж, хэрэгцээтэй лавлагаа тодорхойлолтуудыг 183 иргэнд үнэ төлбөргүй гарган үйлчиллээ.

Сумдын цахим мэдээлэл лавлагааны дүнг нэгтгэж, тайлан мэдээг Харилцаа холбооны зохицуулах хороонд сар бүрийн 05-ны дотор хүргүүлэн ажиллаж байна. Үйлчлүүлэгчдийн хэвлэх, олшруулах үйлчилгээг 241 иргэнд үзүүллээ.

Сумдын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд хяналт-шинжилгээ хийж, холбогдох зөвлөмжийг 18 сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэнд хүргүүллээ.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2021 оны 3 дугаар улирлын хэрэгжилтэд үнэлгээ хийж, 73.64 хувийн биелэлттэйгээр Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан /[unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn)/-д байршууллаа.

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 08-ны өдрүүдэд Тонхил, Дарив, Хөхморьт, Баян-Уул, Жаргалан сумдад ажиллаж, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг танилцуулах сургалтыг зохион байгуулж, бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар зөвлөн тусалж ажиллалаа. Сургалтад дээрх сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, сургууль, цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн төвийн удирдлага, дотоод ажил, шийдвэрийн биелэлт, тайлан мэдээ хариуцсан нийт 85 албан хаагч хамрагдлаа.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн “Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай” зөвлөмж, тэмдэглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (unelgee.gov.mn)-д байршууллаа. Дээрх 2 шийдвэрийн 7 арга хэмжээ 70.0 хувийн хэрэгжилттэй байна.

## ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд захиргааны хэм хэмжээний акт гаргах ажиллагааг хуульд заасны дагуу бүрэн, зөв явуулах, иргэдийн оролцоог идэвхжүүлэх, сумын төрийн албан хаагчдыг мэргэшил арга зүйгээр хангаж, зөвлөн туслах, ажлыг 5 сумд зохион байгууллаа. Сумдад ажилласан ажлын хүрээнд сумын Засаг дарга, орлогч, Тамгын газрын дарга, багийн Засаг дарга, ИТХ, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, татварын байцаагч, эрх зүйн хөтөч, хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн, хэсгийн төлөөлөгч, цагдаа, байгууллагуудын дарга, эрхлэгч нарыг оролцуулан нийт 86 албан хаагчид сургалт зохион байгуулж, захиргааны хэм хэмжээний акт гаргах, албажуулахад анхаарах асуудлуудын талаар мэдээлэл хүргэлээ.

Мөн захиргааны хэм хэмжээний акт гаргахад анхаарах асуудлын талаар зөвлөмж бэлтгэн сумдын Засаг дарга нарт албан бичгээр хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

**Архивын тасаг:** Архивын баримтаас иргэдийн хүсэлтийн дагуу 131 иргэнд мал тооллого, цалингийн лавлагаа болон тушаалын хуулбар нийт 21 хуудас баримт хувилж олшруулан 2672.0 мянган төгрөгийн хураамжийг холбогдох дансанд төвлөрүүлээ.

e-archives.gov.mn программаар 18 иргэний лавлагааг цахимаар хүлээн авч хариуг олгож, иргэдэд архивын лавлагаа, үйлчилгээ үзүүллээ.

“Архивын байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүй ажиллагааны дүрэм”, гамшгийн эрсдэлийн үед урьдчилан сэргийлэх талаар сургалтыг 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж, гал түймэр гарсан тохиолдолд авах арга хэмжээний талаар дадлага сургуулилтыг хийж гүйцэтгэлээ. Дадлага сургуулилтад Төрийн архивын тасгийн 11 албан хаагч оролцож, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэхэд 4 ажилтан ажиллаж Шарга, Чандмань, Баян-уул сумын 9 хадгаламжийн нэгжийн 3005 хуудас бүхий 1555 хүний нэрийг цахим хэлбэрт шилжүүллээ.

**Цагдаагийн газар:** 2021 оны эхний 09 дугаар сард гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 1338 гомдол, өргөдөл мэдээлэл хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн шинжтэй 350, зөрчлийн шинжтэй 988 гомдол, мэдээлэл байна. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 1338 гомдол, өргөдөл, мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 300 нэгжээр буюу 29 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 805 буюу 60,2 хувийг хуулийн анхны хугацаанд шийдвэрлэлээ.

Аймгийн хэмжээнд төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмч хөрөнгөнд 345.9 сая төгрөгийн хохирол учирсан 152 гэмт хэрэг үйлдэгдсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 25 хэргээр буюу 19,7%-иар өсч, учирсан хохирол 260.9 сая төгрөгөөр буюу 43%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 33.3%, үүнээс хүнийг алах гэмт хэрэг 50%, хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэрэг 1 хэргээр, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг 3.5 дахин, хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэрэг 3.5 дахин, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг 50 хувиар, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 1 хэргээр, хүчиндэх гэмт хэрэг 50%, залилах гэмт хэрэг 67%-иар, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 9 хэргээр, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 62.5 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2 дахин тус тус өсч, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 21 хувиар, хулгайлах гэмт хэрэг 41 хувиар, мал хулгайлах гэмт хэрэг 60 хувиар, хөрөнгө завших гэмт хэрэг 66%-иар, хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүй учруулах гэмт хэрэг 50%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Мөн 2021 оны эхний 09 дүгээр сард 152 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнээс согтуугаар 36, гэр орон сууцанд 50, эмэгтэй хүн оролцсон 14, бүлэглэн 17 гэмт хэрэг, хүүхэд оролцсон 6 хэрэг, гэр бүлийн хүчирхийллийн улмаас 11 хэрэг үйлдэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийн илрүүлэлт 47 хувьтай байгааг урьд оны мөн үетэй харьцуулахад 6,5 нэгжээр өссөн. Улсын дундаж 41,9 хувьтай гарсан ба улсын дунджаас 5,1 нэгжээр доогуур байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 47%-ийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн байна.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:** Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны бодит биелэлтийн талаар: 519 гүйцэтгэх хуудасны 3228224.9 мянган төгрөгийг биелүүлэхээс 256 гүйцэтгэх баримт бичгийн 922608.8 мянган төгрөгийн гүйцэтгэх баримт бичгийг биелүүлэн бодит биелэлт 49,3 хувьтай байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.1 хувиар, улсын дунджаас 8.1 хувиар тус тус өсгөн ажиллалаа.

**Шүүхийн шинжилгээний алба:** Тайлант хугацаанд шүүх эрүүгийн хэрэгт мөрдөгч, прокурорын тогтоолыг үндэслэн 1 криминалистикийн шинжилгээ хийж, хэргийн газрын үзлэгт 19 удаа оролцсоноос хүний амь нас хохирсон 5, хулгай 4, зам тээврийн ослын 7, бусад 3 хэрэгт үзлэг шинжилгээ хийлээ.

Эрүүгийн хэргийн тусгай шинжилгээ 15-ыг хийснээс гарын 2, тээврийн хэрэгслийн 7, бусад ул мөр эд мөрийн 6 шинжилгээ хийсэн байна.

Хэргийн газрын үзлэгт 8 удаа оролцож, 474 объектын шинж тэмдгийг бэхжүүлж, зураг авсан. Мөрдөн шалгах бусад ажиллагаанд 13 удаа оролцож, 743 гэрэл зургийн ажил хийлээ.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** Тайлант хугацаанд иргэний бүртгэлийн чиглэлээр лавлагаа олголт-127, гадаад паспорт захиалга-3 тус тус хийгдэж, өдөр тутмын үйл

ажиллагаандаа хууль журмыг тогтмол мөрдөж хуулийн талаарх брошур, гарын авлагыг иргэдэд тараан, үйлчилгээний зааланд байрлуулан сурталчилан ажиллалаа.

Иргэд хуулийн этгээдийн Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 324 мэдүүлэг хүлээн авч шийдвэрлэсэн ба бүртгэлийн үйлчилгээний хураамж 2488.3 мянган төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 142.0 мянган төгрөг, татварын орлого 20853.1 мянган төгрөгийг тус тус улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлээ.

## ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Орон нутгийн төсвийн нийт орлого 6009.8 сая төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 13.7 хувиар буюу 723.5 сая төгрөгөөр давж биелсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 19.3 хувиар буюу 970.9 сая төгрөгөөр илүү үзүүлэлттэй байна.

Төсвийн зарлага 45766.0 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 43104.0 сая төгрөгийн буюу 94.2 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Тусгай зориулалтын шилжүүлгээр 23993.7 сая төгрөг, улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр 10074.8 сая төгрөгийг тус тус хуваарийн дагуу бүрэн авч сум, байгууллагуудын дэмжлэгийг бүрэн олголоо.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээр 4408.4 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 3908,5 сая төгрөгийн санхүүжилт авч 88.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Худалдан авах ажиллагаа:** Тайлант хугацаанд 11,7 тэрбум төгрөгийн 92 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөж, 81 арга хэмжээг хялбаршуулсан буюу цахимаар зарлан, гүйцэтгэл 88 хувьтай байна.

Сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, төсөвт байгууллагын дарга нар болон худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнуудад төрийн худалдан авах ажиллагааны цахим системд ажиллах, шинээр гарсан журам заавруудыг танилцуулах сургалтыг цахим 09 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулж, 62 албан хаагч оролцлоо.

Сургалтын үеэр аймгийн Засаг даргын орлогч Г.Чинбат, зөвлөх Д.Батбилэг болон Орон нутгийн өмчийн газрын дарга, албаны дарга, ахлах мэргэжилтнүүд мэдээлэл хийж, сонирхсон асуултад хариу өгч ажиллалаа.

**Өмчийн асуудлаар:** Худалдах хөрөнгийн жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулж худалдах доод үнийг тогтоох, хөрөнгө бүртгэхийг зөвшөөрөх, хөрөнгө акталж данснаас хасаж үнэ тогтоон худалдан борлуулахыг зөвшөөрөх, хөрөнгө балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрөх, Төрийн өмчид хөрөнгө шилжүүлэхийг зөвшөөрөх тухай асуудлыг тус тус аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал болон ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлээ.

Өмч хувьчлалын орлогоос 59.3 сая, түрээсийн төлбөр 1,6 сая, Дахин дуудлагын худалдаагаар 9.2 сая төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Цахим тендерийн үйл ажиллагааны зохион байгуулалт, Орон нутгийн өмчийн хадгалалт хамгаалалт, өмч эзэмшлийн 2020 оны гэрээ дүгнэх, Улсын үзлэг тооллогын бэлтгэл ажлыг хангуулах зэрэг асуудлаар 2021.09.27-оос 30-ны өдрүүдэд Цогт, Баянтоорой, Цээл, Алтай сумдад ажиллаж, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгууллаа.

## ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

**Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:** Аймгийн хэмжээнд 2021-2022 онд 88 багийн 7915 малчин өрхөд нийт 3163.6 мянган толгой мал өвөлжиж, хаваржих урьдчилсан судалгааг гаргалаа. Малын төрлөөр нь авч үзвэл тэмээ 43.8 мянга, адуу 120.8 мянга, үхэр 75.0 мянга, хонь 934.3 мянга, ямаа 1989.7 мянган толгой байна.

Дотоодын хэрэгцээнд 250.0 мянган толгой мал, зах зээлд 525.0 мянган толгой малыг худалдан борлуулахаар урьдчилсан тооцоо гараад байна.

**Зуншлагын зураглал:** Аймгийн бэлчээрийн ургамлын ургалтын байдал 2021 оны 9 дүгээр сарын 11-ний байдлаар нийт нутгийн 79.0 хувьд хэвийн буюу сайн, 21.0 хувьд дунд удаашралтай гэсэн үнэлгээ гарсан.

**Бэлчээрийн даац:** Бэлчээрийн даацыг нийт нутгаар тооцоход 44.7 хувь нь хэвийн, 55.3 хувь нь бэлчээрийн хүрэлцээ муу гэсэн үзүүлэлттэй байна.

Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах ажлын хүрээнд аймгийн аюулгүйн нөөцөд 150 тн өвс, 100 тн тэжээл, сум бүр аюулгүйн нөөцдөө 100 тн өвс, 30 тн тэжээл бэлтгэх, малчдыг нэмэлт өвс тэжээл бэлтгэх, бэлчээрийн даац хэтэрсэн сумдын малын тоог бууруулах, зах зээлийн эргэлтэд оруулах талаар сумдад үүрэг чиглэлийг өгч ажиллаж байна.

Сумууд аюулгүйн нөөцдөө нийт 1800 тн өвс, 540 тн тэжээл бэлтгэхээс одоогийн байдлаар 81 тн хадлан, 5.7 тн тэжээлийг бэлтгээд байна.

Малчдын түвшинд 1687 тн өвс, 28.5 тн гар тэжээл, 301 тн хужир шүү бэлтгэсэн байна.

**Мал, мах бэлтгэлийн талаар:** Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа “Наяд натур” ХХК нь 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс үйл ажиллагаагаа эхлүүлж бод, бог малыг зумлах аргаар нядалгаанд оруулж байна.

**Отор нүүдлийн чиглэлээр:** Аймаг дундын Бор аргалантын отрын бүс нутагт 2021-2022 онд орж өвөлжих малчин өрх, малын тоо толгойг тогтоох үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн хурал 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр тус аймгийн Дэлгэр сумд зохион байгуулагдаж, аймаг дундын Бор аргалантын отрын бүс нутагт Дэлгэр болон Бууцагаан сумаас нийт 62 өрхийн 42.0 мянган толгой малыг өвөлжүүлэхээр шийдвэрлэсэн. Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг нийт 16.0 мян/га талбайд микробиологийн аргаар тэмцэх ажлыг зохион байгуулсан.

**Газар тариалангийн чиглэлээр:** Тайлант онд аймгийн хэмжээнд нийт 1382 га талбайд тариалалт хийсэн бөгөөд 09 дүгээр сарын 23-ны байдлаар 514 га-аас 1728 тн ургац хураан авсан байна. Үүнд: Үр тариа 10 га-аас 13 тн, төмс 15 га-аас 94 тн, хүнсний ногоо 41 га-аас 172 тн, ногоон тэжээл 423 га-аас 1426 тн, жимс, жимсгэнэ 26

га-аас 24 тн-ыг хурааж, ургац хураалт 39 хувьтай байна. Тус ажилд сайн дурын 28 хүн туслалцаа үзүүлэн ажиллалаа.

Намрын ногоон өдрүүд-2021 нэгдсэн арга хэмжээнд тус аймгаас “Электрон-Алтай”, “Алтай цай ХХК-ууд, Булагт чихэр хоршоо зэрэг аж ахуйн нэгжүүд оролцож 7 хоногийн борлуулалтаараа 50.0 гаруй сая төгрөгийн борлуулалт хийлээ.

**Мал эмнэлэгийн чиглэлээр:** Швейцарын хөгжлийн агентлаг Дарив, Дэлгэр, Баян-Уул сумд хэрэгжүүлсэн Ногоон алт, Малын эрүүл мэнд төслийн хэрэгжилттэй танилцлаа.

Малын гоц халдварт өвчин зүүн, төвийн болон баруун аймгуудад гарсантай холбогдуулан гарсан “Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хориглох тухай” аймгийн Засаг даргын 2021 оны А/418 дугаар захирамжийг хэрэгжүүлэх чиглэлийг сумдын мал эмнэлгийн тасгуудад хүргүүллээ.

Мөн уг захирамжийн хүрээнд Мал эмнэлэгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Сумдын ЗДТГазартай хамтран ажиллаж байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэл 90%, Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэл 86.3 % хувьтай байна.

**Жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр:** Худалдааны салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийн хурал болж, зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээллийг сонсож, холбогдох асуудлыг шийдвэрлэлээ. Тухайлбал “Цэцэрлэгийн хүүхдийн хоол тэжээлийг баяжуулан хийх технологи ажиллагаа”, “Эрүүл зөв зохистой хооллолт-хүнсний бүтээгдэхүүний хоорондын зохицол” сэдэвт сургалтуудыг зохион байгуулах асуудлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр боллоо.

#### ТАВ. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн төв Алтай хотыг 2015-2030 онд хөгжүүлэх “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г тодотгох асуудлыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, дэмжих тухай 64 дүгээр тогтоолыг БХБЯ-нд хүргүүллээ.

Цээл сумын шинэ суурьшлын бүсэд хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажилтай танилцаж, холбогдох үүрэг чиглэл өглөө.

**Дэд бүтцийн салбарт:**Төв суурин газрын 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах аймгийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц 80 хувьтай байна.

Алтай хотын дэд бүтэц бүхий ус, дулаан, цахилгаан эрчим хүчээр хангагч байгууллагуудын ажилтай танилцаж холбогдох үүрэг чиглэлийг өгч, хэрэгжилтийг тооцож ажиллаж байна. Тухайлбал “Ундарга-Алтай” ААТҮГ 10 арга хэмжээ, “Солонго дулааны станц” ААТҮГ 15 арга хэмжээ, “Алтай-Улиастайн Эрчим Хүчний Систем” ТӨХК -8 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг хангасан дүнтэй байна.



Цаг агаарын хувьд дулаан байгаа учир нүүрс, түлш нөөцлөлт харьцангуй удаашралтай байна.

Алтай сумд байрлах Бургастайн хилийн боомтод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудыг байнгын цахилгаан эрчим хүчээр хангах зорилгоор хийгдсэн ЦДАШ, дэд станцын ажлыг хүлээн авах комиссыг томилон ажиллууллаа.

*Сургалт, мэдээллийн талаар:* Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан Өмчийн асуудлаар цахим сургалтад холбогдох албан хаагчид хамрагдлаа.

2. Худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээ олгох сургалтад хамрагдах хүсэлтэй иргэдийг бүртгэн, Төрийн худалдан авах ажиллагааны газар, сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан цахим сургалтад 18 иргэн хамрагдаж, 6 иргэн эрх авлаа.

3. Сумдын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүдэд мал, амьтны шилжилт хөдөлгөөн, отор нүүдлийн шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах, мал угаалгын ажлыг эрчимжүүлэх, бруцеллёзын вакцинжуулалтын ажлыг чанартай зохион байгуулах талаар цахим хэлбэрээр мэдээлэл өглөө.

4. Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төслийн хүрээнд зохиогдсон “Оролцоот эпидемиологийн сургалт”-д аймгийн Мал эмнэлгийн газар болон Шарга, Дэлгэр, Бугат сумдын мал эмнэлгийн мэргэжилтнүүд оролцлоо.

#### ЗУРГАА. НИЙГМИЙН САЛБАР:

Боловсролын чиглэлээр: Хичээлийн жилийн бэлтгэл хангуулах асуудлаар аймгийн төвийн 5 сургуульд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сургалтын хэлбэрийг сонгох эцэг эхийн тандалт судалгааг 28 сургуулийн 6810 эцэг эхийг хамруулан судалгаа хийхэд танхимын болон хосолсон сургалтад хамруулах хүсэлтэй 4739 буюу 69,6 хувь, зайнаас суралцуулах хүсэлтэй 2071 буюу 30,4 хувь байна.

Говь-Алтай аймгийн биеийн тамирын багш нарын мэргэжлийн бүлгийн 2021-2022 оны хичээлийн жилийн анхны хэлэлцүүлэг 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулж, 18 сургуулийн 36 багш оролцож, санал бодлоо солилцлоо.

Оросын соёл шинжлэх ухааны төвийн дэргэдэх орос хэлний төвийг тус аймгийн 2 дугаар сургууль дээр байгуулах хүсэлтийг Оросын соёл шинжлэх ухааны төвд уламжилж, шийдвэрлүүллээ.

Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Коронавируст халдвар /Ковид-19/-ийн үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журмын хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор сургууль бүр “Боловсролын салбарын

эрсдэлийн үнэлгээ”-г асуумж, эрсдэлийн үнэлгээ хийхэд бага эрсдэлтэй 23, дунд эрсдэлтэй 5, их эрсдэлтэй сургууль байхгүй байна.

Ерөнхий боловсролын сургуулийн анги удирдсан багшаар дамжуулан эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдийн насны болон хүйсийн онцлог шинж, давуу тал, хөгжил, хамгаалал, хүмүүжлийн эерэг аргын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, тэдний бүтээлч оролцоог дэмжин хамтран ажиллах нийгэм сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх зорилгоор 2021 оны 09 сарын 20-ны өдрөөс 23-ны өдрүүдэд “Анги удирдсан багшаар дамжуулж эцэг эхийн боловсролыг дэмжих нь” цахим сургалтыг зохион байгуулж, 90 багш хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр бага насны хүүхдийн цогц хөгжлийн стратеги төлөвлөгөөний хүрээнд “Бага насны хүүхдийн цогц хөгжлийн талаар таниулах, залуу гэр бүлд дэмжлэг үзүүлэх аргазүй” сэдэвт сургалтыг зохион байгуулж, аймгийн төвийн 12 цэцэрлэгийн 200 гаруй эцэг эх, Боловсролын хүрээлэнгээс зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй”-н 2 дахь шатны сургалтад бага ангийн 21 багш тус тус хамрагдан, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөдөлгөөний чадвар дадлыг тодорхойлох Т-Тестийг орчуулан, аргачлалыг боловсруулан мэргэжлийн биеийн тамирын багш нарт бичлэг бүхий гарын авлага хүргүүлэн цаашид биеийн тамирын боловсролыг цөм хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг Т-тестийг ашиглан тодорхойлохоор ажиллаж байна.

БШУЯ, Койкагийн олон улсын байгууллагаас хамтран зохион байгуулж буй “Тэгш хүртээмжтэй боловсрол ба түүний эргэн тойронд” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэгт хүүхэд хөгжлийн танхимтай 5 сургуулийн сургалтын менежер, боловсролын газрын мэргэжилтэн нар оролцож, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Төгсөлтийн дараах сургалтад хамрагдаж үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах 11 эмчийн, төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх 3 эмчийн материалыг тус тус хянаж ЭМХТ-д явууллаа.

ЭМХТ-с зохион байгуулж байгаа ариутгагчийн мэргэжил олгох сургалтад 5, “Цар тахлын үеийн эрчимт эмчилгээ, зохиомол амьсгалуулалтын дэвшилтэт технологи, арга аргачлал” сургалтад 4, ХӨСҮТ-с зохион байгуусан “Сүрьеэ дох/тэмбүүгийн” сургагч багшийн сургалтад 4, Сумын эмч нарын холбооноос зохион байгуулсан сургагч багшийн сургалтад 17, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Эх, нярайн тусламж, үйлчилгээний аюулгүй байдал” сэдэвт сургалтад 5, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөс зохион байгуулсан “Covid-19 халдвартай хүүхдийн амьсгалын дутагдлын оношилгоо, 43 эмчилгээ” сэдэвт цахим сургалтанд 24, нийт 6 удаагийн сургалтад 59 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/585 тушаалын дагуу Коронавируст халдвар (Ковид-19)-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан 805 эрүүл мэндийн ажилтанд тус бүр 400.0 мянган төгрөг, нийт 322.0 сая төгрөг олголоо.

Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, коронавируст халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын А/134 захирамж, Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар 6 зорилт 32 заалт төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Коронавируст халдварын эсрэг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Синофарм үйлдвэрийн Вероцелл вакцин 69978 хүн.тун, Герман улсын Комирнети вакцин 14788 хүн.тунг татан авч дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулснаар вакцины 1-р тунд 39041 хүн буюу 66.8 хувь, 2-р тунд 36597 хүн буюу 60.9 хувь нь хамрагдаад байна. Ковид-19 халдвараас сэргийлэх дархлаажуулалтын мэдээг өдөр бүр гарган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 38083 хүн вакцины бүрэн тунд хамрагдаад байна. Вакцинд огт хамрагдаагүй 2581 хүн, зөвхөн 1-р тунд хамрагдсан 2855 хүн байна. Ковидын вакцины нөөц 8954 хүн.тун байна.

Тайлант хугацаанд коронавирусаар батлагдсан хүний ойрын хавьтлын 9611 иргэнийг шинжилгээнд хамруулснаас аймгийн хэмжээнд нийт батлагдсан тохолдол 8045 үүнээс 9 сард 3328 хүн эерэг гарч, нийт батлагдсан тохиолдол 7355 боллоо. Гэрийн эмчилгээнд 9923 хүн эмчилэгдэж байна. Эрүүл Ирээдүй мэс засал гэмтлийн эмнэлэгт 10, тусгаарлан эмчлэх 40 орыг “Тайгам Алтай” зочид буудалд дэлгэх хүсэлтийг ЭМЯ-д хүргүүлээ.

ХӨСҮТ-д графикайн дагуу дельта вирус илрүүлэх шинжилгээнд 6 сорьц илгээхэд 100% илэрсэн нь аймгийн хэмжээнд дельта вирусын дэгдэлт байгааг илтгэж байна. Тайлант хугацаанд нийт шинжилгээний тоо /ПСР болон Түргэвчилсэн /-9611-үүнээс 3328 буюу 34.6 % эерэг гарсан байна. Үүнээс 0-18 насны хүүхдийн өвчлөл 534 буюу 6.6% өмнөх сарын хүүхдийн өвлөлтэй харьцуулахад 217 хүүхдээр илүү өвдсөн үзүүлэлттэй байна

2021 оны тархвар судлалын 38 дугаар долоо хоног буюу 9 дүгээр сарын 27–ны байдлаар аймгийн хэмжээнд амбулаториар 1845 үзлэг хийснээс 36 буюу 2.0% нь, яаралтай тусламжийн 144 дуудлага хүлээн авч үйлчилснээс 16 буюу 11,1% нь томуу томуу төст өвчин бүртгэгдлээ. Өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Томуу томуу төст өвчнөөр өвчлөгсдийн дотор 80.7%-ийг 15, үүнээс 78,5% нь 4 хүртэлх насныхан бүртгэгдэж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 4 хүртэлх насныханд өвчлөл 5%-иар өссөн байна.

Боловсролын 58 байгууллагаас өдөр бүр коронавируст халдварын нөхцөл байдлын мэдээг авч нэгтгэн ЭМЯ, ХӨСҮТ-д хүргүүлж байна. Аймгийн хэмжээнд 16000 орчим суралцагч суралцаж, 700 гаруй ангийн сургалт явагдаж байгаагаас 190 буюу 27% нь коронавирусын халдварын улмаас цахимаар хичээллэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлаар 37 хүүхдийн асуудлыг хэлэлцэн хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн хугацааг сунгаж, үүнээс байнгын асаргаа 1 хүүхдэд шинээр тогтоож, 30 хүүхдийн байнгын асаргааны хугацаанд сунгалт хийлээ. Сургуулийн өмнөх боловсролд 5, ерөнхий боловсролын сургуульд 19 хүүхдийг суралцуулах, бага

насны болон хүнд бэхшээлтэй 13 хүүхдийн гэрийн асаргааг үргэлжүүлэхээр шийдвэрлэлээ.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:** "Хамтарсан баг"-ийн үйл ажиллагаа, үйлчилгээнд шинэ санал санаачилга дэвшүүлэн ажиллах, гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд инноваци нэвтрүүлэх нь" сэдэвт 2 сарын аянг зохион байгуулж байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар "Гэр бүлийн хөгжил хамгаалал" арга хэмжээг батлуулан, уг арга хэмжээг хэрэгжүүлэх 2021-2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран сумдын "Хүүхдийн төлөө зөвлөл", "Хамтарсан баг"-ийн гишүүдийг чадавхжуулах сургалт, "Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо"-ны үйл ажиллагааг сурталчилах, байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх "Эцэг эхийн зөвлөл"-ийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж, 15 сумын 270 хүнийг хамруулан мэдлэг чадварыг нь дээшлүүллээ.

"Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч, ажилтан, албан хаагчдад сэтгэл хөдлөлөө удирдан зохицуулах, өөрийгөө хайрлах, өөртөө цаг гаргах, өөрийн сэтгэцийн эрүүл мэнддээ анхаарах, стрессээ даван туулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор "Өөрийгөө хайрлахуй" сэдэвт сургалтыг үе шаттайгаар зохион байгууллаа.

**Залуучуудын чиглэлээр:** Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, залуучуудын үндэсний хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт, Монгол Улсад залуучуудын хөдөлгөөн үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүнг залуучууд, олон нийтэд сурталчилах, залуучуудад тулгамдаж буй асуудлаар залуучуудын дуу хоолой, санал санаачилгыг сонсох цахим арга хэмжээг 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгууллаа. Уулзалтад 100 гаруй залуу оролцож, мэдээ мэдээлэл авч санал санаачилга солилцон идэвхтэй оролцлоо.

Залуучуудын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, цэвэр агаарыг эрхэмлэх, байгальд ээлтэй, эрүүл амьдралын хэв маягийг бий болгох зорилгоор "ГҮЙЕ-ТҮҮЕ" сайн дурын нөлөөллийн арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээнд 120 хүн оролцож хүмүүнлэгийн болон сайн дурын ажилд оролцох оролцоо нь нэмэгдэж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж, хөдөлгөөний дутагдлаас сэргийлж, эрүүл амьдралын хэв маяг бий болгон, байгаль орчноо хайрлан хамгаалж, ил задгай хог хаяхгүй байх үзлийг төлөвшүүлэн, бусад залуустаа үлгэрлэн, Хантайшир уулын бэлээс гэр хороолол хүртэлх хогийг түүж идэвхтэй оролцлоо.

Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй Монгол гэрийн халаалт, дулаалгын Чип багцыг хэрэглэгч залуу гэр бүл, өсвөр үе, залуучууд хэрэглэснээр орчны бохирдлыг өрхийн хэмжээнд бууруулах арга зам, өрхийн санхүүгийн байдал, эрүүл мэнд гэх мэт тэдний амьдралд гарч байгаа өөрчлөлт, агаарын бохирдлын хор уршиг, эко бүтээгдэхүүний талаар үе тэнгийнхэндээ түгээх, мэдээ мэдээллээр хангах

зорилгоор аймаг, сумдын 26 сургагч багш, олон нийт, үе тэнгийнхэндээ сурталчилан чиглүүлэх 100 хүүхдийг бэлтгэн идэвхжүүлэх сургалт нөлөөллийн ажлыг 10 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл зохион байгуулж үр дүнг тайлагнахаар ажиллаж байна.

Залуучуудын байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ой болон Залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан зохион байгуулж буй “Багадсан дүрэмт хувцасаа бэлэглэе” сайн дурын хандивын аянаар нийгмийн анхаарал, халамж шаардлагатай, зорилтот бүлгийн өрхийн хүүхдүүдэд хувцас хандивлан, сайн дурын үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрөөс 09 дүгээр сарын 07-ны өдрүүдэд зохион байгуулж, уг арга хэмжээнд 32 иргэн оролцож, 7 төрлийн 80 гаруй хувцсыг хандивлан, зорилтот бүлгийн хүүхдүүдэд хүргэлээ.

Монгол Улсын нийт хүн амын 31 хувь, хөдөлмөрийн насны хүн амын 46 хувийг бүрдүүлдэг залуучуудын хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхлыг бий болгож, зөв хандлага, эх оронч үзэл санааг төлөвшүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй “Оролцоо” төслийн сургалт арга хэмжээ амжилттай хэрэгжиж, төслийн сургалтад 44 залуу шаргарч 2021 оны 9 дүгээр сарын 18 нд ажлын байртай болох сургалтад хамрагдаж байна.

Монгол Улсад залуучуудын хөдөлгөөн үүсч хөгжсөний 100 жилийн ой, Залуучуудын хөгжлийн сарын аян, аймгийн Засаг даргын 2021 оны А/63 дугаар захирамж, 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “ЭХ ОРОН” монгол бичгийн уран бичлэгийн уралдааныг 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 20-ны өдрүүдэд зохион байгууллаа. Үндэсний хэл бичгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглээг нэмэгдүүлэх, өсвөр үеийнхэнд үндэсний бичгээ эрхэмлэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх, аймгийн өсвөр үеийн сайхан бичигтнүүдийг тодруулж, нийтэд алдаршуулах, тэдний бичлэгийн дадал, туршлага, авьяас, ур чадварыг сурталчилах, хэл бичиг, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилготой тус уралдаанд Ерөнхий боловсролын 9 сургуулийн, 27 сурагчийн бүтээл ирж, ирүүлсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гарган, шилдгүүдээ шалгарууллаа.

Монгол Улсад Залуучуудын хөдөлгөөн үүсч хөгжсөний түүхт 100 жилийн ой, “Залуучуудын хөгжлийн сарын аян”-ы хүрээнд зорилтот бүлгийн залуу, олон хүүхэдтэй, амьдрах чин хүсэл эрмэлзэлтэй нэг гэр бүлд шалтай, давхар бүрээстэй 5 ханатай гэр олгох “Аз жаргалтай гэр бүл” хандивын аяныг зохион байгуулж, Есөнбулаг сумын Баянхайрхан багийн оршин суугч Т.Батчөдөрийн гэр бүл сонгогдож, 09 дүгээр сарын 30-ны өдөр хүлээлгэн өглөө.

Хүүхэд хамгааллын сайн дурын ажилтан бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд цахим хичээлээ онлайнаар үзэх боломжгүй хүүхдүүдийн боловсролд дэмжлэг үзүүлэх зорилгоор Залуучуудын хөгжлийн төвүүдэд Юнителийн гэр интернэт олгон, дэмжлэг үзүүллээ.

*“Зөв бүхний эхлэл-зөв хандлага”* Хүүхдийн төлөө зөвлөл, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг

сурталчилан таниулах сургалт зохион байгуулж, сургалтад 18 сум, 2 тосгоны 320 хүн хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Бага насны хүүхдийн хөгжил, төлөвшил, эрүүл мэнд, асаргаа халамж, хүүхэд хамгаалал, зохистой хоол тэжээлийн талаар мэдлэг мэдээллийг эцэг эх, асран хамгаалагч нарт хүргэх, хэрэгжүүлэх арга зүйд суралцах цахим сургалтыг 09-р сарын 23-ны өдөр зохион байгуулж, цэцэрлэгийн багш, албан хаагчид болон 200 гаруй эцэг эх хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагаанд хүүхэд, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, уриалан дуудах, татан оролцуулах чиглэлээр зохион байгуулах ажилд хүүхдүүдийн саналыг тусгах зорилгоор ерөнхий боловсролын 6 сургуулийн эко клубын гишүүдтэй бүлгийн ярилцлага хийж, санал солилцох арга хэмжээг 09-р сарын 10-ны өдөр зохион байгуулж, арга хэмжээний үеэр хүүхдүүдэд монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн багцыг танилцуулж, YOUCCAN хөдөлгөөний гишүүн сурагч уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдээлэл хийж, цаашид зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсрууллаа.

Хүүхэд, залуучуудад уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдлын талаар дуу хоолойгоо хүргэхэд нь туслах, тэднийг олон нийтийн яриа хэлэлцүүлэгт оролцоход дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголын скаутын холбоо, Пипл ин Нийд ОУБ хамтран Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Залуучууд, хүүхдүүд уур амьсгалын өөрчлөлт болон цэвэр агаарыг дэмжих нь” төслийг хэрэгжүүлж байна. “Уур амьсгалын өөрчлөлт-Залуусын нүдээр” үндэсний чуулганыг 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 19-ний өдрүүдэд, “Уур амьсгалын өөрчлөлт ба цэвэр орчин төсөл” туршлага солилцох уулзалтыг 09 дүгээр сарын 13-ны өдөр тус тус цахимаар зохион байгуулж, уулзалтад Өмнөговь аймаг, Баянхонгор аймаг, Завхан аймаг, Говь-Алтай аймаг, Баянзүрх дүүргийн төлөөллүүд оролцож, санал бодлоо солилцлоо.

**Насан туршийн боловсролын чиглэлээр:** Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн хүрээнд “Мэргэжлийн чиг баримжаа мэдээллийн төв” байгуулагдаж, тохижилтод 19.0 сая төгрөг зарцууллаа.

Дэлхийн зөн монгол олон улсын байгууллагын Говь-Алтай аймаг дахь салбарын дэмжлэгтэйгээр боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн 4 суралцагчийн сурах үйлийг нь дэмжин иж бүрэн хичээлийн хэрэглэлийг, 1 суралцагчийн сурах үйлийг дэмжин smart education төслийн хүрээнд ухаалаг гар утастай болгон цахим хичээл хийх нөхцөл боломжоор хангалаа.

**Нийгмийн даатгалын чиглэлээр:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын дагуу “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолтод хяналт шалгалт хийх аян” улсын хэмжээнд явагдаж байгаа бөгөөд уг аяны ажлын хүрээнд аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дахин магадлах дэд комисс 962 иргэний картанд үзлэг дүгнэлт хийлээ.

Нийгмийн даатгалын сангаас үйлчилгээ авагч иргэдийн тэтгэврийг 09 дүгээр сарын 01-нд багтаан олгож, олгогдоогүй тэтгэвэр тэтгэмжийн өглөггүй ажиллалаа.

Аймгийн хэмжээнд өндөр насны тэтгэвэр авагч 9244 иргэнд 32163.5 сая төгрөгийг олголоо. Шинээр тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан өндөр настан 45, тахир дутуугийн 11, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 7, нийт 63 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж 93 иргэнд 164.1 сая, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 112 иргэнд 13.9 сая, оршуулгын тэтгэмж 15 иргэнд 15.0 сая, ажилгүйдлийн тэтгэмж 18 иргэнд 8.5 сая төгрөгийг тус тус олголоо.

Сайн дурын даатгалд нийт 44 иргэн хамрагдсанаас ажилгүй 30 иргэн, 0-3 насны хүүхдээ асарч буй 14 эхийг хамрууллаа.

Эрүүл мэндийн даатгалд 599 иргэнийг хамруулж 33.8 сая төгрөг ЭМД-ын санд хуримтлагдлаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 110 хүн орж, үүнээс шинээр 24 хүн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож, 82 хүний групп сунгагдлаа. Цуцлагдсан 4 хүн байна.

**Хөдөлмөр, халамжийн чиглэлээр:** Энэ сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 769 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байгаа ба бүртгэлтэй ажил хайгч иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл 51,2 % нь бүрэн дунд, 30,2% нь дээд, 6,6 % нь техникийн мэргэжлийн боловсролтой байна. Мөн бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны байдлаар нь авч үзвэл 32,7% нь 25-34 насны залуучууд, 15-24 насны залуучууд 13,9 %-ийг, 35-44 насны иргэд 28,8 % -ийг, 45-59 насны иргэд 24,4%-ийг тус тус эзэлж байна. Ажлаас чөлөөлөгдөн ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтэй 45 иргэнийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэн тодорхойлолт гарган өгсөн байна.

Аймгийн 5 байгууллагат 186 ажилтан авахаар захиалга ирүүлсэн ба ажлын байрны заруудыг цахимаар болон байгууллагын зарын самбарт байршуулан иргэдэд мэдээлээд байна.

Орон нутгийн тендерт оролцох хүсэлтэй 9 аж ахуй нэгж байгууллагатай дотоодын давуу эрх тооцуулах хамтын ажиллагааны гэрээг байгуулан ажиллалаа.

Нийгмийн халамжийн үйлчилгээ: Нийгмийн халамжийн тэтгэвэрт 1325 иргэнд 369.4 сая, өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид 123 иргэнд 51.6 сая, жирэмсэн эхчүүдийн мөнгөн тэтгэмжид 483 иргэнд 17.9 сая, 0-3 хүртэлх настай хүүхдээ асарч буй эх, эцгийн тэтгэмжид 2780 иргэнд 136.2 сая, 4 хүртэлх насны 2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмжид 4.0 сая, хүүхдийн мөнгөн тэтгэмжид 20941 хүүхэд хамрагдаж 2094.1 сая, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжид 7 өрх, иргэн хамрагдаж 8.4 сая, нийгмийн халамжийн тэтгэмжийн үйлчилгээнд 1734 хүн хамрагдаж, 156.7 сая төгрөгийг тус тус олголоо.

## ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Цогт сумын Төгрөг гол, Цээл сумын Цээл гол, Чандмань сумын Хүрхрээ голын гадны нөлөөлөлд өртөж

буй байдалд усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэм тогтоох, мөрдүүлэх, тэмдэгжүүлэх ажлыг Премиум эко ХХК-тай 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр гэрээ байгуулан ажлыг эхлүүлээ.

Тус аймгийн Хөхморьт сумын нутагт элсний нүүлт, цөлжилтийг сааруулах зорилгоор 20 га талбайд элсний механик хамгаалалтын ажлыг "Дээдсийн хишиг түшээн" ХХК, 10 га талбайд ашигт шимт ургамал тариалах ажлыг "Бодонгийн ам" ХХК тус тус гүйцэтгэж байгаа бөгөөд дээрх ажлуудын гүйцэтгэлд явцын хяналт шалгалтыг хийн заавар зөвлөмжийг өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Элсний механик хамгаалалтын ажил 12 хувьтай /2.4 га талбайд хийсэн/, ашигт шимт ургамал тариалах ажил 80 хувьтай /талбайг хашаалан, суль цулхир тариалан, салхинаас хамгаалах 1500 улиас бургас тариалсан/ хийгдэж байна.

Мөн ашиг шимт ургамал тариалах ажил үр дүнтэй хийгдэж байгаа бөгөөд 5 жилийн дараа тус тариалсан талбайгаас суль, цулхирыг түүж ашиг шимийг хүртэх боломжтой болох юм.

Монгол Улсын Их Сургууль, ШУАкадеми Биологийн хүрээлэнгийн судлаачид, оюутнууд Алтай Халиун буга ТББ-ын захиалгаар БОАЖГ-тай хамтран Хантайширын нурууны халиун буга болон бусад амьтдын судалгааг 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 09 дүгээр сарын 21-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

Тооллого судалгааны ажилд Тайшир, Халиун, Шарга, Есөнбулаг, Бигэр, Жаргалан сумдын байгаль хамгаалагчид тус газрын мэргэжилтнүүд хамтран оролцож ажиллалаа. Судалгааны ажлын тайлан мэдээ 11 дүгээр сард гарч танилцуулагдана.

**Аялал жуулчлалын чиглэлээр:** Байгаль орчин, аялал жуулчлалын яам, НҮБ-ын Монгол дахь Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл хөтөлбөрийн хамтын ажиллагааны хүрээнд малчин өрхийн аялал жуулчлалаас орлого олох боломжийг бүрдүүлэх, иргэдийн, бие даасан бүлгүүдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний үйл ажиллагааг шинэлэг технологитой холбох, хувийн хэвшилтэй хамтран хөрөнгө оруулах бололцоог нэмэгдүүлэх, тодорхой стандарт бий болгох зорилгоор "Гэр ба Байгаль (G&N)" схемийг аялал жуулчлалын салбарт шинээр томьёолон гаргахаар ажиллаж байна.

Эдгээр асуудлын хүрээнд "Гэр ба Байгаль" схемийн үзэл баримтлал боловсруулах судалгааны явцын тайлангийн хэлэлцүүлэг цахимаар зохион байгуулагдаж, холбогдох 3 албан хаагч хамрагдаж мэдээ мэдээлэл авлаа.

## НАЙМ.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтаар: Төлөвлөгөөт хяналт шалгалт 1, иргэдээс ирүүлсэн өргөдлийн хүрээнд төлөвлөгөөт бус шалгалт 2, зөвлөн туслах үйлчилгээ 1 аж ахуйн нэгж, байгууллагад хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 1 албан шаардлага, 1 зөвлөмж боловсруулан хүргүүлж, 10.1 сая төгрөгийн нөхөн төлбөрийн акт үйлдэн хэрэгжилт 100%-тай байна.

9 сард үйлдвэрлэлийн осол 5 гарч, ослын актыг баталгаажуулах ажил хийгдэж байна. Осолтой холбоотойгоор 3.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээг 1 аж ахуйн



нэгжид ногдуулан, 5 заалт бүхий 1 албан шаардлагыг 1 аж ахуйн нэгжид хүргүүлэн, биелэлт 100%-тай байна.

*Урьдчилан сэргийлэх хяналтын хүрээнд:* Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 01/53 дугаартай удирдамжийн хүрээнд Есөнбулаг сумд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон хувийн хөрөнгөөр барилга угсралт болон засварын ажил гүйцэтгэж байгаа 19 аж ахуй нэгж байгууллага, иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 136 заалт бүхий 8 албан шаардлага 85 заалт бүхий 11 зөвлөмж, Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 01/71 дугаартай удирдамжийн хүрээнд ГАА-ийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2020, 2021 оны нэгдүгээр улирлын “Хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээнд өрх, иргэдийг хамруулсан байдал, орлого бүрдүүлэлт зарцуулалт”-д урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж 5 заалт бүхийн албан шаардлагыг тус тус хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтаар: Төлөвлөгөөт хяналт шалгалт 10, зөвлөн туслах үйлчилгээ 1 аж ахуйн нэгж, байгууллагад хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 8 албан шаардлага, 1 зөвлөмж боловсруулан хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

*Урьдчилан сэргийлэх хяналтын хүрээнд:* Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 01/73 дугаартай удирдамжийн хүрээнд 6 кв болон түүнээс дээш хүчдэлийн түвшинтэй цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурвасын дэглэм сахиулалт, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 8 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хийж, 8 заалт бүхий 4 албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Авто замын хяналтаар: Төлөвлөгөөт хяналт шалгалтыг гүйцэтгэж 18 зөрчил илрүүлж 7 заалт бүхий 2 албан шаардлага, 4 заалттай 2 дүгнэлт үйлдэж, илэрсэн зөрчлийг арилгууллаа.

Барилгын техникийн хяналтаар: 14 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 50%-д нь буюу 7 аж ахуй нэгж байгууллагад шалгалт хийн илэрсэн зөрчлийг арилгуулахаар 38 заалттай 7 албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Зөвлөн туслах: 3 аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөснөөс 1 аж ахуй нэгж, байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхэд дунд эрсдэлтэй үнэлэгдэж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 7 заалттай зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

*Урьдчилан сэргийлэх хяналтаар:* Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 01/38 тоот удирдамжийн хүрээнд Улсын болон орон нутгийн төсөв, гадаад зээл тусламж, төсөл, хөтөлбөр, хувийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр баригдаж буй барилга байгууламж, инженерийн шугам сүлжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж ашиглалт аюулгүй ажиллагааг хангуулан ажиллалаа. Улсын болон хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламжуудыг зураг төслийн дагуу хийгдэж буй эсэхэд хяналт шалгалт хийж аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийж, зөвлөн тусалж ажиллалаа.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 01/57 тоот удирдамжийн хүрээнд 8 соёлын барилга байгууламжийн ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж 43 заалт бүхий 5 албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Эрчим хүчний хяналтаар: 18 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 48%-д нь буюу 8 аж ахуй нэгж, байгууллагад шалгалт хийхэд 2 их, 5 дунд, 1 бага эрсдэлтэй үнэлэгдэж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 83 заалттай 7 албан шаардлага хүргүүлэн, хуулийн хэрэгжилт 58%-тай, эрсдэл үүсэх магадлал 37%–тай байна.

Зөвлөн туслах: 5 аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөснөөс 1 аж ахуй нэгж, байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхэд дунд эрсдэлтэй үнэлэгдэж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 7 заалттай зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилт 68%-тай, эрсдэл үүсэх магадлал 32%–тай байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 01/74 тоот удирдамжийн хүрээнд дулааны эрчим хүчний үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудын халаалтын зуухны техник ашиглалт, аюулгүй ажиллагаа, өвөлжилтийн бэлэн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 6 сумын 23 аж ахуй нэгж байгууллагуудыг хамруулан нийт 56 заалт бүхий 5 хугацаатай албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Автотээвэр өргөх механизмын хяналтаар: Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 01/37 тоот урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд Улсын болон орон нутгийн төсөв, гадаад зээл тусламж, төсөл, хөтөлбөр, хувийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр баригдаж буй барилга байгууламж ачаа өргөх байгууламжийн угсралтын ажил болон автокран техникийн бүрэн бүтэн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж ашиглалт аюулгүй ажиллагааг хангуулан ажиллалаа.

Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 01/83 тоот удирдамжийн дагуу Алтай хот доторх газрын тос, шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийн тээвэрлэлтийн үйлчилгээ эрхэлж буй 19 аж ахуй нэгж байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

**Эрүүл мэнд, боловсрол, соёл, хүнсний чанар, эрүүл ахуйн бодлогын хүрээнд:** Эмчилгээний чанарын хяналт, эм биобэлдмэлийн хяналт, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтаар 3 сумын Эрүүл мэндийн төвд төлөвлөгөөт шалгалт хийж, эмчилгээний чанарын хяналтаар холбогдох хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд Бигэр сумын сум дундын эмнэлэг шаардлага хангахгүй 535 оноо, 33%-аар дунд эрсдэлтэй, холбогдох хуулийн хэрэгжилт 66%, Халиун сумын Эрүүл мэндийн төв 485 оноо, 30%-аар дунд эрсдэлтэй, холбогдох хуулийн хэрэгжилт 70%-тай үнэлэгдлээ.

Эм биобэлдмэлийн хяналтаар 6 эмийн санд төлөвлөгөөт шалгалтыг хийж, холбогдох хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд Ариун тун, Түмэн туяа, Бигэр тун, Ажийн гэрэл эмийн сангууд 20-26%-аар бага эрсдэлтэй, холбогдох хуулийн хэрэгжилт 81-91%, Номгон гэгээн фарм, Шидэт багваахай эмийн сангууд 34-38%-аар дунд

эрсдэлтэй, холбогдох хуулийн хэрэгжилт 69-72%-тай байна. Шалгалтаар илэрсэн зарим зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

МХЕГ-ын даргын баталсан удирдамж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил хангагдсан эсэхэд Боловсрол, хүнсний чанар, стандарт, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтаар хамтарсан урьдчилан сэргийлэх шалгалтад ерөнхий боловсролын 15 сургууль, 16 цэцэрлэг хамрагдаж, шалгалтад хамрагдсан 4 цэцэрлэг засварын үйл ажиллагаа дуусаагүй тул сургалтын үйл ажиллагааг эхлээгүй байна. Шалгалтад хамрагдсан бусад газрууд бэлтгэл ажил хангагдсан байна.

Боловсрол, хүнсний чанар стандартын хяналтаар Халиун сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, Боловсрол, эрүүл ахуй, халдвар хамгаалал, хүнсний чанар стандартын хяналтаар Есөнбулаг сумын 10 дугаар цэцэрлэг, Бигэр сумын ерөнхий боловсролын сургууль, Соёлын хяналтаар Бигэр сумын соёлын төвийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийгдсэн.

Хүнсний чанар, стандарт, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтаар Халиун, Бигэр сумдын 4 хүнсний худалдааны газарт төлөвлөгөөт шалгалт хийж холбогдох хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд 2 объект дунд, 2 объект бага эрсдэлтэй үнэлэгдэж шалгалтаар илэрсэн зарим зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчдын хамтарсан албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Мөн Цогт, Цээл сумд үйл ажиллагаа явуулж буй 2 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид төлөвлөгөөт шалгалт хийж холбогдох хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлж, илэрсэн зөрчилд улсын байцаагчийн 2 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төлөвлөгөөт шалгалт хийгдсэн 3, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн 12 объектод гүйцэтгэлийн хяналт хийхэд улсын байцаагчийн өгсөн зөвлөмжийн биелэлт 40%, албан шаардлагын биелэлт 45%-тай байна. МХЕГ-ын даргын баталсан хяналт шинжилгээний удирдамжийн дагуу Есөнбулаг, Тонхил, Халиун сумдын тариалан эрхлэгч нарын тариалсан төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнээс 40 дээж авч лабораторид шинжлүүлж хариуг хүргүүллээ. Шинжилгээний дүнгээр шаардлага хангасан үзүүлэлттэй гарсан байна.

**Нэгдсэн лаборатори:**Лабораторид 6 Аж ахуй нэгж, 13 иргэн, 9 байгууллагаас хүнсний 5 сорьц 26 үзүүлэлт, ундны усны 20 сорьц 225 үзүүлэлт, төмс, хүнсний ногоо 33 сорьц 121 үзүүлэлт, бусад 3 сорьц 12 үзүүлэлтээр хими хор судлал, нян судлал, таримал ургамал үр хорио цээрийн шинжилгээ хийхэд ундны усны 16 сорьц 23 үзүүлэлт, хүнсний 2 сорьц 2 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй байна. Шинжилгээний нийт төлбөр 475.9 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүллээ.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР